# ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ 2020 ОНД ХЯНАЛТАД ХЭРЭГЖИЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хагас, бүтэн жилийн хурлаар хэлэлцүүлэн, удаашралтай хэрэгжиж буй тогтоол шийдвэрийг эрчимжүүлж ажиллахыг хурлын тэмдэглэлээр үүрэг болгож байна.

## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН

Дундговь аймагт 2020 оны эхний хагас жилийн байдлаар хяналтанд хэрэгжиж буй 33 шийдвэрийн 70 заалтыг хяналтанд авч хэрэгжүүллээ.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2020 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг нэгтгэн, Засгийн газрын 2017 оны 03 сарын 15-ны өдрийн 89-р тогтоолоор баталсан **БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ-**д заасан үнэлгээ өгөх зааврын дагуу үнэлж үзэхэд нийт 70 заалтын биелэлт 82,3 хувьтай хэрэгжиж байна.




Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хагас, бүтэн жил тутамд хэлэлцүүлэн, Dundgovi.gov.mn сайт болон төрийн байгууллагын цахим программ болох и-оффис программын файлын сан хэсэгт байршуулж, мөн мэдээллийн самбар, аймгийн сонингоор дамжуулан төрийн байгууллагыг мэдээллээр хангаж ажиллаж байна.

| | |
|---|---|
| Нийт заалтын тоо | 77 |

| | | |
|---|---|---|
| Бүрэн хэрэгжсэн | 100% | 33 |
| Хэрэгжих шатанд | 70% | 26 |
| Хэрэгжилт хангалтгүй | 30% | 5 |
| Хэрэгжээгүй | 0% | 0 |
| Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй | Хугацаа болоогүй /үнэлэх боломжгүй/ | 13 |
| Хэрэгжилтийн дундаж хувь | 82,3% | |

Шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг танилцах хуудсаар цохолт хийж, харьяа хэлтсүүд хяналтандаа авахаас гадна төрийн байгууллагын цахим и-оффис системд бүх албан хаагчдад нээлттэйгээр байршуулж байна.

Даалгасан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг тогтоосон хугацаанд “Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем” (www.unelgee.gov.mn)-д байршуулж, гарсан үр дүн, үр нөлөөг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хяналт-шинжилгээ хийж үнэлэлт дүгнэлт өгч, тайлагнаж хэвшсэн.

**ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ, БАТАЛГААЖУУЛАХ**

Хуудас ‹ 1 › Нийт хуудас: 1 | Хуудсанд 50 | Нийт: 13

| Тайлангийн мөчлөг | Тайлагнах хугацаа | Тайлагнасан огноо | Тайлагнасан | Төлөв | |
|---|---|---|---|---|---|
| 2020 оны хагас жил | 2020-07-01 | | | Идэвхитэй | тайлагнах |
| 2020 оны 1-р улирал | 2020-03-05 | 2020-03-04 | Г.Самданцоодол | Хяналтад авсан | тайлагнах |
| 2019 оны жилийн эцэс | 2020-01-15 | 2020-01-15 | Г.Самданцоодол | Үнэлгээг хяналтад авсан | тайлагнах |
| 2019 оны 3-р улирал | 2019-09-20 | 2019-09-20 | Г.Самданцоодол | Үнэлгээг хяналтад авсан | тайлагнах |
| 2019 оны хагас жил | 2019-07-01 | 2019-06-28 | Г.Самданцоодол | Үнэлгээг хяналтад авсан | тайлагнах |
| 2019 оны 1-р улирал | 2019-03-28 | 2019-03-28 | Г.Самданцоодол | Үнэлгээг хяналтад авсан | тайлагнах |
| 2018 оны жилийн эцэс | 2019-01-15 | 2019-01-15 | Г.Самданцоодол | Үнэлгээг хяналтад авсан | тайлагнах |
| 2018 оны 3-р улирал | 2018-10-30 | 2018-10-30 | Г.Самданцоодол | Үнэлгээг хяналтад авсан | тайлагнах |
| 2018 оны хагас жил | 2018-07-05 | 2018-06-28 | Г.Самданцоодол | Үнэлгээг хяналтад авсан | тайлагнах |

2019 оны жилийн эцсээр Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэлээр хэлтсийн дарга нарт удаашралтай заалтыг эрчимжүүлж ажиллах чиглэлээр хугацаатай үүрэг чиглэл өгснөөр харьяа хэлтэс, агентлагуудад тавих хяналт, хэрэгжилтийг зохион байгуулах ажил сайжирч байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС